



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 291 дүгээр тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 291 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын хүснэгтэнд доор дурьдсан агуулгатай 7 дахь мөр нэмсүгэй:

1/

д/д	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/
7	Даатгалын мэргэжлийн оролцогч компанид салбар байгуулахыг зөвшөөрөх 7.1. Улаанбаатар хот 7.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	100000 20000

2. Журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000168